

ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН “ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2008.02.20

2007 оны жилийн эцсийн байдлаар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.

Д.д	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл						
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо		Хөтөлбөрийг Засгийн газрын 2005.04.01-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор баталсан.						
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа		2005 - 2010 он						
3	Хөтөлбөрийн зорилго		Хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэхэд оршино.						
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: - жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх; - төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох; - жижиг, дунд үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих; - жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох.						
		1 дүгээр үе шат: 2005–2006 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	а/ Жижиг, дунд үйлдвэр хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх, журам, стандарт, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулах, шинэчлэн батлуулах; б/ “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-г шинэчлэн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” болгон зохион байгуулж ажиллуулах; в/ Төрийн үйлчилгээний талаарх санал хүсэлт, гомдлыг хүлээн авах “Шуурхай үйлчилгээний цэг”-ийг байгуулах; г/ Мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж шийдвэр боловсруулах явцад санал, зөвлөмж авч байх; д/ Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн цэгийг хэрэгцээг харгалзан нэмж байгуулах; е/ Лиценз, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбарчлах, цахим сүлжээгээр олгох; ж/ Хөрөнгийн асуудал шийдэгдэх хэмжээгээр бизнес инкубатор, технологи дамжуулах төв байгуулах						
		2 дугаар үе шат: 2007–2008 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	а) I үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг дуусгах; б/ Технологи дамжуулах төвийг хот, суурин газар болон бүсийн төвүүдэд байгуулах; в) Бизнес инкубаторыг бүсийн төв, хотод байгуулах; г) Мэргэжлийн сургалтын төвүүдийг бүсийн төвүүд, хот суурин газруудад байгуулах.						
		3 дугаар үе шат: 2009–2010 он	Энэ үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн үед нь баталж мөрдөнө.						
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	Нийт 19410.0 сая төг. (Үүнээс 15 000.0 сая төгрөг нь Мянганы сорилтын сан, Японы Засгийн газрын 2 үе шаттай зээл, бусад)						
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/, үүнээс	2006, 2007 оны нийт эх үүсвэрээс олгосон зээлийн байдлаар авч үзвэл 249 төсөл хүлээн авснаас 241 төсөл банкинд шилжүүлж, 110 орчим төсөлд 2603.9 сая төгрөгийн зээл олгосон байна.						
		тухайн жилд зарцуулсан							
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Нийт	100	90-95	80	75	60-65	Дундаж
		Хөтөлбөрийн I шатны зорилт	4	1	2		1		90%
		Хөтөлбөрт дэвшүүлсэн 2007-2008 оны зорилт	4			1 (1)	1 (3)	2 (2,4)	70%

7	Зорилт	Төлөвлөсөн үйл ажиллагаа, арга хэмжээ	Гүйцэтгэл	хувь
	<p>“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчине бүрдүүлэх” зорилтын 5 үйл ажиллагааны хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p>2008 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад 2007 онд хэрэгжилтийн явц нь дунджаар 80 хувьтай байна.</p> <p>(100+90+70+70+70)/5</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулж, батлуулах, хэрэгжих хугацаа: 2005</p>	<p>I шат:</p> <ul style="list-style-type: none"> - Жижиг, дунд үйлдвэрийн шалгуур үзүүлэлтийг судалгааны үндсэн дээр гаргаж хуулийн төсөлд оруулсан. - “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан, ХЗДХ-ийн сайд Д.Одбаяр нар 2006.04.24-ний өдөр хамтран баталсан. Хуулийн төслийг 2006 оны 6-р сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барив. <p>II шат:</p> <ul style="list-style-type: none"> - 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн УИХ-ын чуулганаар “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлуулсан. <p>ЖДҮ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг бусад яамдын төлөөлөлтэйгээр байгуулан төлөвлөгөөг Үйлдвэр, худалдааны сайдын - Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар бусад яамдын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулж, Жижиг, дунд үйлдвэрийн хэрэг эрхлэх газрын дүрэм, бүтэц, зохион байгуулалт, төсөв, Үндэсний зөвлөлийн дүрэм, ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг боловсруулж, Сайдын зөвлөлийн 2007.11.27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, яамдаас санал авч, Засгийн газрын 2007.11.28-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч шинэ Засгийн газар байгуулагдсантай холбоотойгоор дахин санал авахаар буцаасан. Саналыг авч хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. 	100
		<p>Татварын болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох хуулийн төсөл боловсруулж батлуулах; хэрэгжих хугацаа: 2005</p>	<p>I шат:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж, санал боловсруулав. - “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Гаалийн татварын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулав. Татварын хуульд оруулах нэмэлт өөрчлөлтын саналыг оруулан, хэлэлцүүлэн УИХ-ын 2006 оны 6 дугаар сард батлагдсан. - Судалгаа хийж, татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Сангийн яаманд оруулж УИХ-ын 2006 оны 7-р сард батлагдсан. - “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн төсөлд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг нэмж тусгуулах саналыг боловсруулж Сангийн Яам болон УИХ-ын Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хороонд хүргүүлэв. “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг тусган 2006.06.29-нд УИХ-аар батлуулсан. <p>II шат:</p> <p>Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах саналыг холбогдох яамдад хүргүүлэн хамтран ажиллаж УИХ-аар 2007 онд батлуулсан.</p>	90
		<p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тэргүүлэх чиглэлийг боловсруулж батлуулах</p>	<p>II шат:</p> <ul style="list-style-type: none"> - ЖДҮ-ийн тэргүүлэх чиглэлийг “ЖДҮ-ийн тухай хууль”-д тусгаж баталгаажуулсан. - Нийслэлийн ЖДҮ-ийн тэргүүлэх чиглэлийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж, тэргүүлэх чиглэлийг баталгаажуулахаар саналыг оруулсан. 	70
		<p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийн барьцааны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тогтолцоог</p>	<p>I шат:</p> <ul style="list-style-type: none"> - “Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл”-ийн журамд өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. 	

		бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх; хэрэгжих хугацаа: 2006		
		Техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх. хэрэгжих хугацаа: 2006	I шат: Лизингийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж Засгийн газрын хуралдаанаар оруулан УИХ-д 2006 оны 6 дугаар сард өргөн бариад батлуулсан. II шат: -“Санхүүгийн түрээсийн хуулийг хэрэгжүүлэгчийн гарын авлага”-ыг эмхтгэн гаргаж, уг хуулинд татварын зарим хуулиудыг хэрэгжүүлэх аргачлалыг тусган 1000 хувь хэвлүүлэн холбогдох газруудад тараасан. -НХХЯ, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран лизингийн тухай сургалт, зөвлөлгөөн зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, орон нутгийн захиргааны ажилтнуудыг оролцуулсан. - Арилжааны банкнуудтай хамтран ажиллах саналыг хүргүүлээд байна.	70
		Төлөвлөгөө батлуулах, Үндэсний зөвлөл байгуулсан байх	I шат: Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны 84, 85 тоот тушаалаар уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан, Үндэсний зөвлөлийг байгуулан ажиллаж байна. II шат: - ЖДҮ-ийг дэмжих Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг ЖДҮ-ийн тухай хуульд заасны дагуу шинэчлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.	70
	<i>“Төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох” 2 дахь зорилтын 3 үйл ажиллагааны хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөсөн.</i> <i>2008 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад 2007 онд хэрэгжилтийн явц нь дунджаар 60 хувьтай байна.</i> <i>(60+50+70)/3</i>	Лиценз, зөвшөөрөл, бүртгэлийн ажиллагааг хялбаршуулах талаар доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ: хэрэгжих хугацаа: 2005-2006 - Төрийн захиргааны бүх шатны байгууллагаас аливаа бүртгэл, лиценз, зөвшөөрлийг цахим сүлжээгээр олгодог тогтолцоог бүрдүүлэх, хэвшүүлэх; - Бизнес эрхлэхэд саад тотгор болж буй хууль, тогтоомж, бүх шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хянан үзэж, зарим лиценз, зөвшөөрөл, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий дүрэм болон хураамжийг хүчингүй болгох; - Бүх шатны Засаг дарга, Тамгын газраас гаргасан үйлдвэрлэл, үйлчилгээг журамласан шийдвэрийг хянан үзэж, хууль тогтоомжид нийцүүлэх; - Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн нэгжийн тоог олшруулах, бүртгэлийг хөнгөвчлөх, хураамжийг үйчилгээний өөрийн өртөгтэй нь нийцүүлэн тогтоож мөрдөх.	I шат: - Бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зорилгоор “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоолоор батлуулав. II шат: - Бизнес эрхлэгчдэд ногдож байгаа хураамжийн ачааллыг багасгах талаар судалгаа хийж санал боловсруулна. - Үйлдвэр, худалдааны чиглэлээр олгогдож буй тусгай зөвшөөрлийг Үйлдвэр Худалдааны сайдын тушаалаар баталсан журмын дагуу яаманд нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр явуулж байна. Нэг цэгийн үйлчилгээний самбар мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна. - Нийслэлтэй хамтран нэг цэгийн мэдээллийн үйлчилгээг дүүрэгт бүрт бий болгохоор ажиллаж эхний ээлжинд Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын дэргэд байгуулан ажиллуулж байна. Сонгино-Хайрхан, Баянзүрх дүүрэгт ЖДҮ-ийг дэмжих төвд “мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ” ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. - Төрийн захиргааны бүх шатны байгууллагаас аливаа бүртгэл, лиценз, зөвшөөрлийг цахим сүлжээгээр олгодог тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж зарим төрлийн лизензийг цахим сүлжээгээр олгож эхэлсэн.	60
		Хяналт, шалгалтын тогтолцоог хялбаршуулах талаар доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ: - Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон заавал	I шат: - Бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зорилгоор “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоолоор батлуулж заавал мөрдөх стандартын тоог бууруулсан.	

		<p>мөрдөх стандартаас бусад стандартыг аль болох зөвлөмжийн шинж чанартай болгож цөөрүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Улс, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд хяналт, шалгалтын давхардлыг арилгах, хяналт шалгалтыг бизнес эрхлэгчдэд зөвлөл-гөө өгөх, мэдээллээр хангахад чиглүүлэх; - Улсын байцаагчийн дүгнэлтийг бүх шатанд хүлээн зөвшөөрөх журамд шилжих замаар хяналт шалгалтын тоог цөөрүүлэх; - Хувийн өмчийн халдашгүй дархан байдлыг хангах үүднээс шуурхай шалгалт хийх онцгой нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд улсын мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс хувийн өмчид хяналт шалгалт хийхдээ байгууллагын удирдлага буюу өмчийн эзнээс бичгээр зөвшөөрөл эрх зүйн үндсийг бий болгох. 	<p>II шат:</p> <ul style="list-style-type: none"> - Улс, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд хяналт, шалгалтын давхардлыг арилгах, хяналт шалгалтыг багасгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, давхардлыг багасгасан; 	50
		<p>Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хүрээнд хувийн хэвшил, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, хуулинд нууцад хамааруулснаас бусад шийдвэртэй иргэд чөлөөтэй танилцах орчинг бүрдүүлэх; - Бизнесийн холбоотой аливаа шийдвэрийн төслийг боловсруулах, хэлэлцэхдээ олон нийтийн саналыг урьдчилан авдаг журмыг хэвшүүлэх; - Төрийн үйлчилгээний талаархи санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах шуурхай цэг ажиллуулах. - Мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж, шийдвэр боловсруулах явцад оролцуулж байх 	<p>I шат:</p> <ul style="list-style-type: none"> - “Шуурхай үйлчилгээний цэг”, “Нэг цэгийн мэдээллийн үйлчилгээ”-г эхлүүлсэн. <p>II шат:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн ЗДТГ-тай хамтран дүүргүүдэд “Нэг цэгийн мэдээллийн үйлчилгээ”-г бий болгох ажлыг хийж байна. - Үйлдвэр, худалдааны чиглэлээр олгогдож буй тусгай зөвшөөрлийг Үйлдвэр Худалдааны сайдын тушаалаар баталсан журмын дагуу яаманд нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр явуулж байна. Нэг цэгийн үйлчилгээний самбар мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна. - Гомдол саналыг шуурхай шийдвэрлэх цэгийг ажиллуулахаар хөрөнгийн асуудлыг 2008 оны Улсын төсөвт тусгуулсан. - Мэргэжлийн Холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж үйл ажиллагаа нь явагдаж байна. Мэргэжлийн Холбоодын нэгдсэн зөвлөлтэй хамтран ажиллах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах үед Холбоодоор дамжуулан бизнес эрхлэгчдийн саналыг тусгаж байна. 	70
<p>“Жижиг, дунд үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих” 3 дахь зорилтын 2 үйл ажиллганы хүрээнд 10 арга хэмжээг төлөөлөсөн.</p> <p>2008 онд хүрэх үр дүнтэй</p>		<p>Жижиг, дунд үйлдвэрийг татварын болон нийгмийн даатгалын бодлогоор дэмжих хүрээнд:</p> <p>/хэрэгжих хугацаа: 2005/</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрийг эхний 3 жилийн хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх; - Жижиг, дунд үйлдвэрийн зар 	<p>I шат:</p> <ul style="list-style-type: none"> - “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “ААНОАТ-ын тухай хууль”, “Гаалийн татварын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан Сангийн яаманд оруулан УИХ-ын 2006 оны 7 дугаар сард батлуулсан. - Нийгмийн даатгалын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор холбогдох судалгааг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, МОНУХ-ноос авч, санал дүгнэлт бэлтгэв. - Жижиг, дунд үйлдвэрийн зар сурталчилгаа, сургалтын зардал, сайн дурын даатгалын хураамж, хэвийн хорогдол, урсгал засварын зардал зэрэг бизнесийн бодит зардлыг татвар ногдуулах зардалоос хасаж тооцооноор “ААНОАТ-ын тухай хууль”-д өөрчлөлт оруулан батлуулсан. 	

<p>харьцуулахад 2007 онд хэрэгжилтийн явц нь дунджаар 75 хувьтай байна.</p> <p>(70+80)/2</p>	<p>сурталчилгаа, сургалтын зардал, сайн дурын даатгалын хураамж, хэвийн хорогдол, урсгал засварын зардал зэрэг бизнесийн бодит зардлыг татвар ногдуулах орлогоос хасаж тооцох;</p> <p>- Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай импортоор оруулах техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх.</p> <p>- Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийн импортолж байгаа үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж шийдвэрлэх;</p> <p>- Ажил олгогчоос авч байгаа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бууруулах асуудлыг судалж шийдвэрлэх;</p> <p>- Гаалийн жишиг болон хэлцлийн үнэ бүрдүүлэх нээлттэй механизмийг бий болгоход тарифын зөвлөл, импортлогчдийн оролцоог нэмэгдүүлэх.</p>	<p>II шат:</p> <p>- Нийгмийн даатгалын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор холбогдох судалгааг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, МОБҮХ-ноос авч, санал дүгнэлт бэлтгэж оруулсны дагуу Нийгмийн даатгалын хууль 2007 онд батлагдсан. Ажил олгогчоос авч байгаа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 19.5 хувь байсныг бууруулж 10 хувь болгож батлуулсан.</p>	<p>70</p>
	<p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжих хүрээнд:</p> <p>/хэрэгжих хугацаа: 2005-2008/</p> <p>- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалт, хөгжлийн сан байгуулж ажиллуулах;</p> <p>- Жижиг, дунд үйлдвэрт зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох, нэмж олох талаар Сангийн яам, Монгол Банк, арилжааны банкуудтай хамтран арга хэмжээ авах;</p> <p>- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр жижиг, дунд үйлдвэрийн төслийг санхүүжүүлэх, төслийн хэрэгжилтэд мэргэжлийн холбоодын зөвлөлөөс хяналт тавих боломжийг бий болгох;</p> <p>- Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөрийн арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах.</p>	<p>I шат:</p> <p>- Улаанбаатар хотын Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан байгуулав. Энэ сангаас өссөн дүнгээр 2005 оноос 2006 оны эхний улирал хүртэлх хугацаанд 9 аж ахуй нэгж, иргэдэд 38.6 =(23.5+15.1) сая төгрөгийн зээл олгосон.</p> <p>- ЖДҮ эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих ажлыг эрчимжүүлэх, төсвөөс гаргах хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих зорилгоор Үйлдвэр, худалдааны сайдын 2006.03.06-ны 29 тоот тушаалаар ажлын хэсгийг батлуулан ажилласан.</p> <p>- ҮХЯ - Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан, Монгол шуудан банкны хооронд байгуулсан 2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн гэрээний дагуу 1.8-2.2 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатай зээлийг жижиг бизнес эрхлэгчдэд олгож байна. 2003 оноос 2005 оны 10 дугаар сарын 31-н хүртэлх хугацаанд Монгол Шуудан банкнаас давхардсан тоогоор 21 аймгийн 382 хүнд 814.92 сая төгрөгийн зээл олгосноос 315 хүний 628.5 төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 80 хүний 202.4 сая төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байв. Үүнээс шинэчилсэн гэрээний дагуу 2006 оны 6-9-р сард 29 хүнд 72.02 сая төгрөгийн зээл олгосон. Нийт олгосон зээлийн эргэн төлөлт нь 77.1 хувьтай байна.</p> <p>- Үйлдвэр, худалдааны сайдын 2006.03.06-ны 29 тоот тушаалын дагуу Төсвийн зээлийг олгох журам, Банкуудтай хамтран ажиллах гэрээ, төсөл шалгаруулах комиссын бүрэлдэхүүн, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус байгуулж ҮХСайдын 2006.11.09-ний өдрийн 198 тоот тушаалаар батлав.</p> <p>- ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх зээлийг олгох талаар хамтран ажиллах банкуудыг шалгаруулж, банкуудтай зээлийн хүүг сарын 1 хувь, банкуудаас гаргах эх үүсвэрийг 20-30 хувь байхаар тохирч, 2006.11.08-10-ны өдрүүдэд ҮХ-ны</p>	

			<p>сайд Б.Жаргалсайхантай хамтран ажиллах гэрээг Монгол Шуудан, Зоос, Хас банкуудтай байгуулав.</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн зээлийг олгох асуудлаар 4-н бүс, УБ хотын дүүргүүдэд шаталсан сургалтыг явуулж байна. 2006.11.23-нд УБ хотын СХДүүрэгт Бичил зээл олгох талаар 100 бизнес эрхлэгчдэд зориулан ҮХЯ-наас зээл авахад шаардагдах материал, бизнесийн төлөвлөгөө боловсруулах болон бусад санхүүгийн эх үүсвэр олоход туслах зорилгоор Хас, Зоос, МШ Банкуудтай хамтран сургалт явуулав. - 2006.11.26-нд Ховд аймгийн Ховд хотод Бичил зээл олгох талаар 50 бизнес эрхлэгчдэд зориулан ҮХЯ-наас зээл авахад шаардагдах материал, бизнесийн төлөвлөгөө боловсруулах болон санхүүгийн эх үүсвэрээс зээл авахад туслах зорилгоор Хас, Зоос Банкуудтай хамтран сургалт явуулав. - 2006 оны Улсын төсөвт тусгасан 1 тэрбум төгрөгийг ЖДҮ эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих ажлын хүрээнд зээл банкаар дамжин олгох ажил хийгдэв. - Японы 2 үе шаттай зээлийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэв. 2006 оны 3 дугаар сард Япон-Монголын Ерөнхий сайдуудын хэмжээнд зээлийн гэрээнд гарын үсэг зурагдсан. Сангийн яам арилжааны 6 банкиг сонгож, ХХБ, Хас, Зоос, Капитрон, Голомт, Хаан банкуудтай дамжуулдан зээлийн гэрээ байгуулаад байна. - Нэг суурин Нэг бүтээгдэхүүн санаачилгын хүрээнд 150 сая.төг-ийн Зээлийн баталгааны санг НҮБХХ-ийн эх үүсвэрээс бүрдүүлж, Хас банкттай хамтран хэрэгжүүлэх гэрээнд 300 сая.төгрөгийн зээлийг олгохоор ҮХЯ, НҮБХХ, Хас банк нарын хооронд гэрээг 11-р сарын 17-нд байгуулав. “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн санаачилга”-ын хүрээнд хот, орон нутагт нээлттэй тендер зарлаж, тухайн орон нутгийн бренд бараа, үйлчилгээг бий болгох зорилготой ажиллаж байна. Гол дэмжлэг нь Эрсдэлийн санд НҮБХХ-өөс 30.000 ам.доллар, зээлд “ХАС” Банк 100.000 ам.доллар олгохоор тохирч, Бичил зээлийн батлан даалтын гэрээнд 2006 оны 5-р сарын 30-нд ҮХ-ны дэд сайд Я.Содбаатар, НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн орлогч Мела Ватукавака, Хас Банкны гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг нар гарын үсэг зурсан. Тус сангийн хүрээнд Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байгаа бүлийн 18-н гишүүнээс зээл авахаар хүсэлт ирүүлж, 7-н гишүүнд 11.408.641 төгрөгийн зээлийг 2006 оны 7-р сараас эхлэн, 6 сараас 12 сарын хугацаатайгаар сарын 1.6 - 1.8 хүүтэйгээр түүхий эд худалдан авах, тоног төхөөрөмж худалдан авах, ажлын байр барих зориулалтаар олгосон. - НҮБХХ-өөс Монгол банкинд байрлуулсан 150 сая төгрөгийн эх үүсвэрийг Бичил санхүүжилтийн эх үүсвэр болгон Монголд үйлдвэрлэл хөгжлийн төслийн “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” санаачилгыг дэмжих зорилгоор ашиглахаар НҮБХХ-тэй ажилаж байна. - Бичил Санхүүжилт Шинэлэг Санаачилга Тэтгэлэгт Хөтөлбөрийн хүрээнд дараахь ажлыг гүйцэтгэв. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Газар Тариаланг Дэмжих Сангийн хүрээнд Төв аймгийн Баянчандмань суманд бүлийн бүтцээр ажиллаж байгаа 20 хүн, Борнуур суманд 30 хүнд гишүүн тус бүрт 300.000 төгрөгийг 1 хувийн хүүтэй 7- 8 сарын хугацаатайгаар 15 сая төгрөгийн зээлийг 2006 оны 4-р сард олгосон. /Эх үүсвэр: 35 сая төг/ 2006 оны эцсийн гүйцэтгэлээр MIGA Зөвлөлөөс хяналт хийхэд 2 гишүүнээс бусад нь эргэн төлбөр хийх бүрэн боломжтой байна. - АДРА ТББ-ын хувьд Хөвсгөл аймгийн Тариалан сум, Завхан аймгийн Улиастай, Алдархаан суманд үйл ажиллагаа явуулж байна. АДРА ТББ нь ХААН банкттай хамтран ажиллах гэрээг байгуулж, НҮБХХөтөлбөрөөс нийт 61 450 000 төгрөгийн санхүүжилт хийж, давхарсан тоогоор 10 орчим сая.төгрөгийн зээл олгоод байна. - АЧИД Группын хүрээнд Баянхонгор, Хөвсгөл аймгийн 	
--	--	--	---	--

		<p>Баянцагаан, Тариалын сумуудад Банк Бус Санхүүгийн Байгууллагыг шинээр байгуулж, дүрсийн сангийн дийлэнхи хэсгийг нутгийн иргэдийн оролцоотойгоор байгуулж ажиллаж байна. НҮБХХ-өөс санхүүжүүлсэн 77 413 088 төгрөгийн санхүүжилтээс ББСБ-ыг байгуулахад дүрмийн сангийг бүрдэл, захиргааны зардлууд болон зээл олголтонд тодорхой хувиараар зарцуулсан болно.</p> <p>II шат:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэр, худалдааны сайдын 2007 онд 140 тоот тушаалаар төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн болон комиссын ажиллах журмыг баталгаажуулсан. СЯ-нд Удирдах хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. ХААН, Капитрон, ХХБ, Хас, Зоос, Голомт банкинд нийт 43 зээлийн материал ирснээс одоогийн байдлаар 14 төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна. - 2007 онд Засгийн газар улсын төсвөөс гаргасан 1 тэрбум төгрөгийг аймаг орон нутагт гурван талт гэрээний үндсэн дээр 2007 оны 5-р сараас эхлэн хуваарилсан. Улсын төсвөөс гаргаж буй 1 тэрбум төгрөг дээр нэмээд аймаг, орон нутгаас 643.0 сая төгрөг, оролцогч арилжааны банкууд дээрх 2 эх үүсвэрийн 30 хувьтай тэнцэх хөрөнгө нэмж, нийт 2 тэрбум 2267.3 сая төгрөгийн хөрөнгө төвлөрөхөөр тооцоо гарсан боловч Хөвсгөл, Дундговь, Дорнод аймгууд дэд сан байгуулах гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулагдсан боловч Архангай, Баян-Өлгий, Дархан-уул, Сэлэнгэ, Хэнтий зэрэг аймгууд хөрөнгөө төвлөрүүлээгүйгээс үйл ажиллагаа тасалдаж, тэрбум 831.3 сая төгрөг төвлөрсөн. 2007 онд орон нутагт 473.6 сая төгрөг, Улаанбаатар хотод 569.3 сая төгрөг, нийт 1 тэрбум 42.9 сая төгрөгийн зээл олгосон. - ЖАЙКА-тай хамтран “Зээлийн баталгааны журам боловсруулах тухай” төсөл боловсруулан Японы ЗГ-аас Техникийн туслалцаа авахаар хүргүүлсэн. Одоогийн байдлаар ЖАЙКА дэмжихээ илэрхийлсэн. - “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе” төслөөс “Зээлийн баталгааны сан” байгуулах ажлыг 2006 оноос эхэлж, баталгааны хөрөнгийг нэмэгдүүлэх замаар 2007 онд баталгааны санг 300.000 ам.доллар болгож, энэ баталгаанд 516 сая төгрөгний зээл олгох үйл ажиллагаа эхлээд байна. Дээрх ажлын хүрээнд 50-80 хүртэл хувийн баталгаагаар бүлийн зээлийг 19 бүлд буюу 156 хүнд 60 сая төгрөг, “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн”-ий зээлийг 5 бүлийн 46 иргэн, аж ахуйн нэгжид 76 сая төгрөг олгоод байна. Дараагийн ээлжийн бүлийн зээл авах иргэдийн зээлийн материалыг судлан зээл олгох талаар Хас банкинд зөвшөөрөл олгоод байна. - “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” санаачлагын талаар дүүрэг, хотын иргэдэд ойлголт өгөх зорилгоор нийслэлийн бүх дүүргийн тус хөтөлбөрийг хариуцсан ажилтнуудыг оролцуулсан семинар зохион байгуулж, Налайх, Багануур, Чингэлтэй дүүрэг, Завхан аймагт баруун бүсийн 5 аймгийг хамарсан сургалт зохион байгуулсан. - 2006 онд 140 гаруй бүтээгдэхүүний санал ирсэнээс 8 бүтээгдэхүүнд техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, 50 хүртэлх хувийн баталгаа гарган хөнгөлөлттэй зээл олгох зэрэг үйл ажиллагаа явуулсан. 2007 онд Бүсчилсэн хөгжлийн ажлын албатай хамтран дахин сонгон шалгаруулалтыг зарлаж, 51 төслөөс 5 бүтээгдэхүүнийг сонгоод үйл ажиллагааг эхлээд байна. - 2006 онд 7 бүтээгдэхүүнд, 2007 онд 5 бүтээгдэхүүнд техникийн туслалцаа /гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг ажиллуулах, сав, баглаа боодлыг сайжруулах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, танилцуулга бэлтгэх/ үзүүлсэн. - Төвүүдийн дэргэд загвар бүл бий болгох сонгон шалгаруулалтыг явуулж, тэнцсэн ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бичил бизнес эрхлэгчдийг бүл болгон 50 	80
--	--	---	----

			<p>хүртэлх хувийн баталгаа бүхий хөнгөлөлттэй зээл олгож байна.</p> <p>- Болгар улсын ЖДҮ-ийг дэмжих агентлагтай хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурахаар ажлын хэсэг ажиллаж байна.</p> <p>- Японы 2 үе шаттай зээлээс ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцлөөр төслүүдийн сонгон шалгаруулалт хийгдэн эхний 3 зээлдэгч зээлээ аваад байна.</p> <p>- ГТХАН-ийн шугамаар хэрэгжиж байгаа “Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих” төслийн хүрээнд Mercy Corps-той хамтран Завхан, Өвөрхангай аймагт зээлийн баталгааны сан байгуулах ажил эхэлж байна.</p> <p>2006, 2007 оны нийт эх үүсвэрээс олгосон зээлийн байдлаар авч үзвэл 249 төсөл хүлээн авснаас 241 төсөл банкинд шилжүүлж, 110 орчим төсөлд 2603.9 сая төгрөгийн зээл олгосон байна.</p>	
	<p>“Жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох” 4 дэх зорилтын хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөсөн.</p> <p>2008 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад 2007 онд хэрэгжилтийн явц нь дунджаар 65 хувьтай байна.</p> <p>(80+70+50+50)/4</p>	<p>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Бизнес инкубаторуудыг байгуулах; хэрэгжих хугацаа: 2005-2006</p>	<p>I шат:</p> <p>- Бизнес инкубаторын үлгэрчилсэн дүрэм батлах дүрмийн төслийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Үйлдвэр, худалдааны сайд нарын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Бизнесийн Инкубатор, Технологи дамжуулах төв байгуулах тухай төслийг бэлтгэн Олон улсын байгууллагууд ТИКА, КОИКА, Японы ЭСЯ/ болон гадаад донор орнуудад хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>- Үйлдвэр, худалдааны яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хооронд байгуулсан Үйлдвэр, худалдааны салбарын бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу Япон улсын ЭСЯ-нд “Өвсний үндэс” төслийн хүрээнд Нийслэлийн захын дүүрэгт Бизнес инкубатор байгуулах саналыг тавьсан байна.</p> <p>- НҮБХХ-тэй хамтран “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе” төслийн туслалцаатайгаар 4-н бүс, Улаанбаатар хотод Бизнесийг дэмжих Зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулсан. Үүний үр дүнд 2006 онд Зүүн бүсэд Хэнтий аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Хэнтий аймгийн Хэрлэн сумын “Хэрлэн бизнес хөгжлийн нийгэмлэг” төрийн бус байгууллага, Төвийн бүсэд Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ-Итгэлт” ажил олгогч эздийн холбоо, Баруун бүсэд Ховд аймгийн “Хоршооллын сургалт мэдээллийн Боломж - Ирээдүй төв”, Хангайн бүсэд ШУТИС-ийн Өвөрхангай аймаг дахь Технологийн их сургууль, Улаанбаатар хотод “Бичил бизнес, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэгдсэн холбоо” ТББ-ыг, орон нутагт биеэ даасан “Бичил бизнесийг дэмжих төв”-үүдийг бий болгож гэрээний дагуу судалгаа, зөвлөх үйлчилгээ, тухайн орон нутагт үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн, бизнесийн талаар цогцолбор сургалтын арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Зүүн бүсэд Бизнесийн сургалт - 4, ур чадварын сургалт - 7 удаа, 268 хүн, Төвийн бүсэд Бизнесийн сургалт - 3, ур чадварын сургалт - 5 удаа, 240 хүн, Хангайн бүсэд Бизнесийн сургалт - 4, ур чадварын сургалт - 2 удаа, 207 хүн, Баруун бүсэд Бизнесийн сургалт - 3, ур чадварын сургалт - 5 удаа, 133 хүн, Улаанбаатар хотод Бизнесийн сургалт - 2, ур чадварын сургалт - 2 удаа, 45 хүн хамрагдаж, нийт 45 сургалтанд 893 хүн хамрагдав.</p> <p>II шат:</p> <p>- “Бизнес инкубаторын дүрэм батлах тухай” БСШУ-ны, НХХ-ийн тушаал (2006-6-15-ны өдрийн 219 /59 /89 тоот) гарган хэрэгжүүлж байна.</p> <p>- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шугамаар Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Увс аймагт болон Налайх дүүрэгт өмнө байгуулагдсан бизнес инкубаторуудын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Улаанбаатар хот /4/, Завхан, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад бизнес инкубатор төвүүд</p>	80

		<p>шинээр нэмж байгуулсаны зэрэгцээ Улаанбаатар хот, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий, Орхон аймгуудад бизнесийн хөгжлийг дэмжих төвүүд байгуулсан.</p> <p>- Сонгино хайрхан, Баянзүрх дүүрэгт Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, инкубаторын хамт байгуулахаар 2007.09.14-ний өдөр сонин, хэвлэлээр нээлттэй тендер явуулахаар зарласан. 2007.10.22-ний өдөр нээлттэй тендерийг задалж, ирүүлсэн тендерийн материалыг үнэлэн, Баянзүрх дүүрэгт “Ану хорол” ХХК, Сонгинохайрхан дүүрэгт “Харандаа” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулсан. Гэрээний дагуу төвийн байрыг худалдан авах, бичиг баримтыг шилжүүлэхээр Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн төрийн өмчит “ЖДҮ-ийг дэмжих төв”-ийг байгуулав.</p> <p>- ЖДҮ-ийг дэмжих төвд тавилга, компьютер худалдан авах тендерийн саналын үнэлгээ, үнэлгээний товчоо хийж 3 байгууллагатай гэрээ хийж тавилга техник хэрэгслэлийг Нийслэлийн орон нутгийн өмчөөр худалдан авсан.</p> <p>- ШУТИС-ийн Үйлдвэрлэл, технологи, дизайны сургуулийн Эдийн засаг, менежментийн төгсөх ангийн оюутнуудын тусламжтайгаар Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн судалгааг хийж мэдээллийн санг бий болгосон.</p>	
	<p>Бүсийн төвүүдэд Технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; хэрэгжих хугацаа: 2005-2006</p>	<p>1 шат:</p> <p>- Монгол улсын Засгийн газраас 2005 оныг Бичил Санхүүжилт, Жижиг, Дунд Үйлдвэрийг Дэмжих жил болгон зарласантай холбогдуулан НҮБХХ, ҮХЯ хамтран “Бичил санхүүжилт Шинэлэг Санаачилга Тэтгэлэгт Хөтөлбөр”-ийг 2 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж эхэлсэн. НҮБХХөтөлбөрөөс Бичил Санхүүжилт Шинэлэг Санаачилга Тэтгэлэгт Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр бүрэн санхүүжүүлсэн ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3 байгууллагыг сонгон шалгаруулжээ. Үйлдвэр, Худалдаа-ны Яам НҮБХХ, “МҮХ”-тэй хамтран 2006.12.06-ны өдөр “Бичил Санхүүжилт Шинэлэг Санаачилга Тэтгэлэгт Хөтөлбөр” сэдэвт семинарыг Улаанбаатар хотод зохион байгуулж, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар мэдээллийг семинарт оролцогсоод хүргэв.</p> <p>Сургагч багш нарын ахисан шатны сургалт явуулах бэлтгэл ажил хангагдсан. Сургалтын материал, номыг дахин хэвлэлтэнд бэлэн болгосон байна.</p> <p>- Төв аймгийн Жаргалант, Батсүмбэр сум болон Дархан-Уул аймгийн бизнесийн инкубаторт “Бизнесээ хөгжүүл” шатны сургалт явууллаа.</p> <p>- НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж байгаа “МҮХ” төслийн хүрээнд “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн санаачилга”-д зориулан Японы Засгийн газраас 300.000 ам.долларын санхүүгийн эх үүсвэрийг шийдсэн бөгөөд 4-р сарын 19-нд гэрээнд ҮХ-ны сайд Б.Жаргалсайхан, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Мета Пратива, Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайд Ишихаши нар гэрээнд гарын үсэг зурсан. “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” санаачлагын хүрээнд 140 гаруй санал ирснийг шалгаруулж, 8 бүтээгдэхүүнийг дэмжин брэнд бүтээгдэхүүн болгохоор бодит дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>- Уг санаачлагын хүрээнд үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийн хүрээнд бүс орон нутагт зохион байгуулж байгаа семинар, сургалтанд, 2006.09.22-23-нд Баянхонгор аймагт “Хангайн Бүс түншлэл”, 2006.10.25 - 26-нд Ховд аймагт “Баруун Бүс Түншлэл” арга хэмжээнд оролцож, Бүсийн хөгжилд ЖДҮ-ийн оролцооны талаар илтгэл, 2006.06.18-19-нд Увс аймгийн Улаангом хотод, 2006.09.17-19-нд Сэлэнгэ аймагт ЖДҮ Эрхлэгчдийн зөвлөгөөнүүдийг тус бүр ЖДҮТХХ нь “МҮХ”Төсөл, ГТХАН-ийн “Экспортын Баримжаатай Үйлдвэр,</p>	

			<p>Худалдааны Бодлого” төсөлтэй хамтран орон нутгийн Жижиг, дунд үйлдэр эрхлэгчдэд зориулж зохион байгуулав.</p> <p>- ҮХЯ, “МҮХ” Төсөл, Бүсчилсэн Хөгжлийн Үндэсний Хороотой хамтран 2006 оны 12-р сарын 16-ны өдөр Нэг Суурин Нэг Бүтээгдэхүүн сэдэвт Үндэсний Зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд Нэг Суурин Нэг Бүтээгдэхүүн Зөвлөлийн дарга, Монгол улсын Шадар сайд М.Энхсайхан, Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ичихаши Ясуоши, НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн орлогч хатагтай Шоко Нодо нар оролцож Нэг Суурин Нэг Бүтээгдэхүүн санаачилга хөдөлгөөны 2006 онд хийсэн ажлын тайлан, цаашид хийх ажлын талаар илтгэл, мэдээллүүдийг санал болгов. Семинарт Монгол Улсын 21 аймгийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, төсөл хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудын төлөөлөл болох нийт 70 хүн оролцов. Зөвлөгөөнөөс Нэг суурин Нэг Бүтээгдэхүүн санаачилга хөдөлгөөнийг нийт улс орон даяар идэвхи санаачилгатай, эрчимтэй өрнүүлэх зорилгоор Уриалга гаргав.</p> <p>- “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэе” төслийн хүрээнд “Нэг суурин, нэг бүтээгдэхүүн хөтөлбөр”-тэй нийцүүлэн орон нутагт тухайн орон нутгийн брэнд бараа, үйчилгээг бий болгоход сургалт, зөвлөгөө өгөх, бараа, үйлчилгээг дэмжих мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зорилгоор сонгон шалгаруулалтыг нийтэд зарлан явуулж, хүлээн авсан 140 гаруй саналаас шалгарсан 9 аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>- 2006 онд 7 бүтээгдэхүүнд техникийн туслалцаа /гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг ажиллуулах, сав, баглаа боодлыг сайжруулах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, танилцуулга бэлтгэх/ үзүүлсэн. 2006 онд шалгарсан 7 бүтээгдэхүүнээс өнөөдрийн байдлаар “Боломж сан”-гийн “Хаан” нэртэй гар хивс олон улсын 3 үзэсгэлэнд амжилттай оролцсон. Сэлэнгэ аймгаас шалгарсан зөгийн бал, Завхан аймгаас шалгарсан улаан сармис зэрэг бүтээгдэхүүний сав баглаа боодлын асуудлыг шийдвэрлэж, экспортод гаргахаар ажиллаж байна. Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Хэнтийн Дадал сумын “НИТАЖ” /нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал/-д гадаадын мэргэжилтнүүдийг ажиллуулж, зөвлөлгөө өгөх сургалт зохион байгуулсан.</p> <p>II шат:</p> <p>- Технологи дамжуулах төв байгуулах төсөл боловсруулан 2008 оны улсын төсөвт оруулахаар оруулсан. 2008 оны эхний хагас жилд багтаан Улаанбаатар хотод байгуулахаар төлөвлөөд байна.</p> <p>- ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох ажлын хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлэх ажлын хүрээнд тус хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтыг 9 удаа хийж, 113 багш бэлтгээд байна. Мөн ОУХБ-ын тусламж, дэмжлэгтэйгээр хөтөлбөрийн үндэсний мастер багш бэлтгүүлж авсан. Тус хөтөлбөрийн сургалтын материал /10 ном, товхимол/-ыг Монгол хэлнээ хөрвүүлж, Монголын нөхцөлд тохируулж, хэвлүүлэн ашиглаж байна. “БЭБХ” хөтөлбөрийн сургалтыг Улаанбаатар хот, 21 аймагт 108 удаа зохион байгуулж, 1212 хүнийг сургаад байна.</p> <p>- “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” санаачлагын хүрээнд дамжлэг үзүүлэх /2007 оны/ 2 дахь шатны сонгон шалгаруулалт явуулахаар өдөр тутмын хэвлэлээр нийтэд зарлан 51 бүтээгдэхүүний саналыг хүлээн авч, 5 бүтээгдэхүүнийг шалгаруулан дэмжлэг үзүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>- 2007 онд 5 бүтээгдэхүүнд техникийн туслалцаа /гадаад, дотоодын мэргэжилтнүүдийг ажиллуулах, сав, баглаа боодлыг</p>	70
--	--	--	---	----

			сайжруулах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, танилцуулга бэлтгэх/ үзүүлсэн.	
		Жижиг, дунд үйлдвэрийн удирдлага, инженер техникийн ажилтныг их, дээд сургууль, коллежид, ажилчдыг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг түшиглэн мэргэжил дээшлүүлэх, мэргэшил эзэмшүүлэх сургалт зохион байгуулах хэрэгжих хугацаа: 2005-2008	II шат: Бизнесийн сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд ОУХБ-ын хүүхэд, залуучуудад зориулсан "Бизнестэй танилц" сургалтын хөтөлбөрийг 2007 оноос туршилтаар, 2008 оноос бүх ЕБС-уудын ахлах ангиуд, МСҮТ-үүдийн суралцагсдад үндсэн хөтөлбөрийн хүрээнд заах тухай шийдвэр БСШУ, ҮХ, НХХ сайдын хамтарсан тушаалаар гарч уг хөтөлбөрийг Монголд нэвтрүүлэх Үндэсний зохицуулах хороог батлан ажиллаж байна. Тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд ОУХБ-ын "Бизнестэй танилц" хөтөлбөрийн материалууд /11 ном, сурах бичиг/-ыг орчуулах, хянах, тохируулах ажлыг хийж, туршилтын сургалт явах Улаанбаатар болон 12 аймгийн 15 дунд сургууль, 6 МСҮТ, сургууль, завсардсан хүүхдүүдтэй ажилладаг 3 ТББ-д 24 багш бэлтгэн холбогдох материал, сурах бичгээр бүрэн хангасаны зэрэгцээ 3600 суралцагсдад хүрэлцэх хэмжээний ном, сурах бичгийг хэвлүүлэн хүргүүлэв. Арга хэмжээнд тохируулан биелэлт гахгах	50
		Төрийн бус байгууллага, зөвлөлгөө өгөх төв зэрэг жижиг, дунд үйлдвэр дэмжих үүсгэл санаачлагын байгууллагын үйл ажиллагаа болон томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тулгуурлан мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих.	ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох ажлын хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл" хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлэх ажлын хүрээнд тус хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтыг 9 удаа хийж, 113 багш бэлтгээд байна. Мөн ОУХБ-ын тусламж, дэмжлэгтэйгээр хөтөлбөрийн үндэс-ний мастер багш бэлтгүүлж авсан. Тус хөтөлбөрийн сургалтын материал /10 ном, товхимол/-ыг Монгол хэлнээ хөрвүүлж, Монголын нөхцөлд тохируулж, хэвлүүлэн ашиглаж байна. "БЭБХ" хөтөлбөрийн сургалтыг Улаанбаатар хот, 21 аймагт 108 удаа зохион байгуулж, 1212 хүнийг сургаад байна. Арга хэмжээнд тохируулан биелэлт гахгах	50
7	<i>Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц</i>	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн. УИХ-ын чуулганаар "Жижиг, дунд үйлдвэрийн тухай" хуулийг 2007 оны 7 дугаар сард батлуулсан. "Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай" хуулийг 2006 оны 6-р сард батлуулав. Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий салбарын жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ажлын хэсэг байгуулан ажиллаж, санал боловсруулав. "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай", "Гаалийн татварын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулав. Татварын хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг оруулан, хэлэлцүүлэн УИХ-ын 2006 оны 6 дугаар сард батлагдсан. Татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Сангийн яаманд оруулж УИХ-ын 2006 оны 7-р сард батлагдсан. Бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зорилгоор "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 222 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоолоор батлуулав. ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх зээлийг олгох талаар хамтран ажиллах банкуудыг шалгаруулж, хамтран ажиллах гэрээг Монгол Шуудан, Зоос, Хас банкууд байгуулав. Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 198 тоот, 2007 онд 140 тоот тушаалаар төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн болон комиссын ажиллах журмыг баталгаажуулсан. Улсын төсвөөс 2006, 2007 онуудад тус бүр 1 тэрбум төгрөг гаргуулан орон нутгийн төсвөөс мөн тэр хэмжээний хөрөнгийг, оролцогч арилжааны банкуудаас эх үүсвэрийн 20-30 хувийг нэмэгдүүлэн гаргаж ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож байна. 2006, 2007 оны нийт эх үүсвэрээс олгосон зээлийн байдлаар авч үзвэл 249 төсөл хүлээн авснаас 241 төсөл банкинд шилжүүлж, 110 орчим төсөлд 2603.9 сая төгрөгийн зээл олгосон байна. "Бизнес инкубаторын дүрэм батлах тухай" БСШУ-ны, НХХ-ийн тушаал (2006-6-15-ны өдрийн 219 /59 /89 тоот) гарган хэрэгжүүлж байна. НҮБХХ-ийн "Монголд үйлдвэрлэл хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шугамаар хот, орон нутагт биеэ даасан Бичил бизнесийг дэмжих төвүүдийг бий болгож гэрээний дагуу судалгаа, зөвлөх үйлчилгээ, тухайн орон нутагт үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүн, бизнесийн талаар цогцолбор сургалтын арга хэмжээг зохион байгуулж байна. Төвүүдийн дэргэд загвар бүл бий болгох сонгон шалгаруулалтыг явуулж, тэнцсэн ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа бичил бизнес эрхлэгчдийг бүл болгон 50 хүртэлх хувийн баталгаа бүхий хөнгөлөлттэй зээл олгож байна. ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох ажлын хүрээнд Олон		

		улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлж сургагч багш бэлтгэх сургалтыг удаа дараа зохион байгуулж, багш нар бэлтгээд байна. “БЭБХ” хөтөлбөрийн сургалтыг Улаанбаатар хот, 21 аймагт 108 удаа зохион байгуулж, 1212 хүнийг сургаад байна.
8	<i>Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтын үр дүн, үр ашиг, үр өгөөж/</i>	Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны 2005-2006 оны биелэлт 90 хувь, хоёрдугаар үе шатны 2007 оны жилийн төлөвлөгөөний биелэлт нь өссөн дүнгийн дунджаар 70 хувьтай байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдсэн. Жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжих арга хэмжээг сайн хэрэгжүүлж байна. ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох талаар тодорхой ажил хийгдэж байна. Хөтөлбөрт заагдсан дараах ажлуудын хэрэгжилт удаашралтай байна. Үүнд: - Хяналт, шалгалтын тогтолцоог хялбаршуулах, - Технологи дамжуулах төв байгуулах, - Гаалийн жишиг болон хэлцлийн үнэ бүрдүүлэх нээлттэй механизмийг бий болгоход тарифын зөвлөл, импортлогчдийн оролцоог нэмэгдүүлэх, - ... мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих зэрэг арга хэмжээнүүд орж байна. Төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн хуралдаанаас ЖДҮ эрхлэгчдийн зээлийн дэмжлэг хүсэн ирүүлсэн төслүүдийн 96 орчим хувийг банк шилжүүлсэн боловч дөнгөж 45 хувьд зээл олгогдсон байна.
9	<i>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал</i>	- Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүй байгаа, ЖДҮ-ийг дэмжих зээлийн эх үүсвэр урт хугацаат хөнгөлөлттэй зээлийн асуудлын шийдвэрлэгдэх хугацаа удаашралтай, ЖДҮ-лэгчдийн мэдлэг боловсрол, чадвар дутмаг, үйлдвэрлэлийн технологийн мэргэшлийн ажилчны бэлтгэл зэргээс хамаарч уг хөтөлбөрийн зарим арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх хандлага ажиглагдаж байна. - Олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас Монгол улсын Засгийн газрын шугмаар ирж буй ЖДҮ, бизнесийг дэмжих төслийн зээл"-ийн хүүг нь манай Арилжааны банкаар дамжуулж зээл олгох явцад өсгөхгүй байхад анхаарах.
10	<i>Эдгээрээс гарах арга зам</i>	Зөвлөмж: - Татварын болон бусад хууль тогтоомжид оруулан баталсан нэмэлт, өөрчлөлт, бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах, хураамжийн ачааллыг багасгах талаар хийгдсэн ажлуудын үр дүнг тогтоосон судалгаа явуулж, танилцуулж байх; - ЖДҮ-чдэд олгох зээлийн баталгааны асуудалд анхаарах, зээл олгогч банкуудын зээл олголт, эргэн төлөлтийн байдалд дүгнэлт өгөн, хамтын ажиллагааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, - Японы 2 үе шаттай зээлийн хэрэгжилтийг үр дүнтэй болгох талаар арга хэмжээ авах, - Хот, орон нутагт байгуулсан бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, ХШ хийж, үнэлгээ өгөх, удирдамж, зөвлөмжөөр хангах, - ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.
11	<i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ</i>	Энэ хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд яамд, банк санхүү, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хоршоод, их дээд сургуулийн хамтын ажиллагааг улам сайжруулах.
12	<i>Хөтөлбөрийн талаархи яамны санал</i>	- Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, төлөвлөсөн цаг хугацаатай хамааралтай асуудлыг шуурхай шийдвэрлэх. - Технологи дамжуулалтын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулан батлуулах асуудлыг шийдвэрлэх, хөрөнгийн асуудал шийдэгдэх хэмжээгээр технологи дамжуулах төв байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим бэрхшээлтэй асуудлыг Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтарч шийдвэрлэх, мөн Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх.

Танилцсан: *ҮБЗГ-ын дарга*
МХШҮХ-ийн дарга

Д. Бадарч
Ц.Мэнд-Амар

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайлан гаргасан:
ЖДҮТХХ-ийн мэргэжилтэн

Б.Батцэцэг

Хяналт-шинжилгээний үнэлгээ, зөвлөмж өгсөн:
МХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Д. Алтанлит